



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 184

Жаргалант

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг
түр хугацаанд хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, Улсын Онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2020 оны 4-р сарын 29-ны А/130 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт 2020 оны 5-р сарын 01-ны өдрөөс 5-р сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглосугай.

2. Хориглосон хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаж, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг үүсгэж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж болон гар дээрээс худалдан борлуулсан иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, ахлагч /П.Буяндэлгэр/, Засаг даргын орлогч /Ж.Хүрэлбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд, ард иргэдэд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ